

ИХ ХӨЛГӨНИЙ ОНОЛЫН ГОЛ ЗАРЧМУУДААС

Т.Булган - МУИС.НШУС, Шашин Судлалын Тэнхим, дэд профессор

Түлхүүр үг: Сургаалийн товчоо, "Их нигүүлсэх сэтгэл", "Бодь сэтгэл", "Хоёр үгүйд үзэх ухаан гурав", Төв үзлийн ялгамжаа онцлог (Талжүрва), барамидууд, хоосон чанар, бодгалийн би үгүй, номын би үгүй, хоёр үнэн, шүтэн барилдахуй, арга ба билиг,

Товч утга: Хамаг амьтан бүгд жаргахыг хүснэ. Хэн ч зовохыг үл хүснэ. Энэ бол хүн төрөлхтний түгээмэл нийтлэг нэгэн, мөнхийн хүсэл эрмэлзлэл. Амьдралын эрхэм дээд зорилгын нэгэн. Энэ зорилгодоо хүрэх янз бүрийн арга зам, мэдлэг туршлага, арга замыг хүн төрөлхтөн хөгжлийнхээ түүхэн замын туршид нээж илрүүлж амьдрал ахуйдаа хэрэглэсээр иржээ. Цаашдаа ч мөн ингэж жаргалтай сайхан амьдрах арга замын төлөө эрэл хайгуулаа үргэлжлүүлэх нь магад. Буддха энэ л зорилгын төлөө, энэ, олон амьтны сайн сайхан амьдрахын хүсэл эгээрэлд тус болохын тулд өөрийн үзэл онол, сургаал номоо зориулсан нэгэн билээ.

Чингэж хамаг амьтны тусын төлөө түүний айлдсан ном сургаалын эрхэм гол нь их хөлгөний сургаал мөн бөлгөө.

Их хөлгөний гурван үндэс:

1. Их нигүүлсэхүй,
2. Бодь сэтгэл,
3. Зөв үзэл буюу хоосон чанарыг онох ухаан"

1. "Их нигүүлсэхүй сэтгэл" (karuna, great compassion):

"Их нигүүлсэхүй сэтгэл" гэдэг ерөнхий утгаар бол хамаг амьтныг үл хөнөөх, үл хорлохын мөн чанарт бөгөөд "тэдний зовлонд сэтгэл өвдөж хамаг амьтан зовлонгоос хагацаасай, хагацвал юун сайн, би зовлонгоос нь хагацуулсугай" хэмээн тангараглах хүртэлх сэтгэлүүд багтана гэж үзнэ.

Эл сэтгэл их хөлгөний эрдэм ухааныг бүтээх мөрийн эхэн, дунд, эцэс гурвууланд их ач тустай тул ир хөлгөний гэж үздэг. Их энэрэн нигүүлсэхүй сэтгэл нь Ялгуусан бурхадын хотол чуулсан энэхүү тариаланг тариалахад эхнээсээ хөрөнгө адил үүсгэж төрүүлэх ач тустай, улмаар дээш дээш дэгжээх ус адил завсар зуурт ач тустай, эцэстээ боловсорсон үр жимс адил шавь нар өнө үргэлжид ач үрийг эдлэх орон болох ач тустай. Их нигүүлсэхүй сэтгэл нь эхлээд их хөлгөний мөрд орохын үүдийг нээгч буюу "гол үндэс" болно.. Улмаар завсарт хөлгөний эрдэм ном төгс болох "нөхцөл шалтгаан" болно. Эцэст нигүүлсэхүй сэтгэлтэйн эрхээр хэзээ амьтны зовлон дуусах хүртэл бурхад бодьсатва нарын бусдын тусыг шамдан бүтээх "эзэт нөхцөл" зэрэг нөхцөл болдог аж. Энэ талаар Энэтхэгийн их эрдэмтэн Чандракирти бээр: "Төв үзэлд орохуй" Мадхьямакавтара шастартаа:

Алины тул нигүүлсэхүй сэтгэл нь Ялгуусны хотол чуулсан энэхүү

Тариалангийн хөрөнгө бөгөөд улам аривжуулагч ус адил мөн.
Өнөд удаан үргэлж эдлэх орон боловсорсон үр тариа адил буюу
Иймээс эхлээд нигүүлсэхүй сэтгэлийг магтсу би" хэмээжээ.

Их нигүүлсэхүй сэтгэлд “Амьтныг зорьсон нигүүлсэхүй”, “Номд зорьсон нигүүлсэхүй” болоод “Зоригдол үгүй нигүүлсэхүй” гэсэн гурван сэтгэл байна.

А. “Амьтныг зорьсон нигүүлсэхүй”: “Ертөнцийн доройтол бүхний үндэс нь “би-д баригч-, миниймхийлэн баригч, зөвхөн өөрийн тусыг бодогч аминч, мунхаг сэтгэл байдаг. Тэр мунхаг сэтгэл түүнээс үүдэх буруу үзлээс ертөнцийн элдэв зовлон буюу “самсара” хүрд үүдэж, тэр хүрдний эргүүлгэнд орж, худгийн ховоо нэг дээш нэг доош буун эргэлдэх адилаар зовлонгийг далайд өөрийн эрхгүй орсон амьтныг тухайлан зорьж, чухам юунаас болж зовж буй үндэс шалтгааны үүднээс энэрэн нигүүлсэж буй сэтгэлийг энд багтаан үзжээ.

Энэ талаар: “Төв үзэлд орохуй”-гаас:

Эхлээд “Би” хэмээн өөртөө шунах бөгөөд

Энэ “Минийх” хэмээн бодитой шунал төрнө.

Худгийн ховоо мэт өөрийн эрхгүй болсон

Амьтныг энэрч нигүүлсэхүй сэтгэлт танаа мөргөмү хэмээжээ.

Б. “Номд зорьсон нигүүлсэхүй”: Эл сэтгэл дээрхийн адил амьтныг энэрэх нигүүлсэхүйн мөн чанар адил бөгөөд гагцхүү зовсон амьтны мөн чанар, тухайлбал мөнх бус зэргийн жамыг санаж энэрэх сэтгэлийг энэ айд багтааж үздэг байна. Энэ талаар Монголын гүн ухаантан Зава Дамдин гавж бээр: “Их нигүүлсэхүйн магтаал- нэг зуун найман болор эрхи” –ээс:

“Амьтан бүхэн усны хуниарчилан

Агшин нэгэн төдий ч тогтох үгүй

Мөнх бусыг тийн болгоох

Номд зорьсон их энэрэнгүй таныг магтму” хэмээн тодорхойлсон буй..

В. “Зоригдол үгүй нигүүлсэхүй”: Эл нигүүлсэхүй нь зовсон амьтныг энэрэхдээ тухайн амьтан өөрийн мөн чанараар бүтсэн мэт үзэгдэвч, үнэхээр бүтсэн зовлонтой мэт санагдавч, угтаа бол тэр зовлон, тэр амьтан бүгдээр усны доторхи сарны дүрстэй адил хоосон, хуурмаг мөн чанартайг болгоож, амьтны мөн чанар хоосон, үнэхээр зоригдох, тухайлагдах, баригдах орон бус болохыг ухаарахын үндсэн дээр зовсон амьтныг ахуй ёсны үүднээс энэрэх сэтгэл болно гэж үздэг.

“Төв үзэлд орохуй”-гаас:

“Амьтан гэдэг мяралзан урсах усны доторхи саран мэт

Урсах бөгөөд өөрийн мөн чанараа хоосныг үзсэн” хэмээжээ.

2.-“Бодь сэтгэл”(Bodhichitta; Awakening mind):

Бодь сэтгэл нь их хөлгөний үүд болох нь: Хамаг амьтны тусыг бүтээхийн тулд бурханы хутагыг олсугай хэмээн эгээрэх их төрөлхтөн хүний их сэтгэл. Өөрийнхээ тусад бус зөвхөн бусдад туслах, зөвхөн бусдын төлөө хэмээх цаглашгүй үйл хэргийг бүтээхээр их үүрэг хариуцлагыг өөртөө хүлээж, тэр үүргээ биелүүлэхийн тулд оюун ухааны хөгжил боловсролын дээд хутаг болсон бурханы эрдэм ухааныг чухалчлан эгээрэх, их нигүүлсэл, энэрлийн

үндэст “Бодьсадва нарыг мэндлүүлэгч эх”, “Их хөлгөнөө орох гагц үүд” Их хөлгөний хамаг мөрийн товчоон” болсон дээд бодь сэтгэл.

Эл утгыг Шантидэва гэгээн “Бодисадвын явдалд орохуй”- даа:

“Асралт бодь сэтгэл төрсөн тэр агшнаа

Амаргүй сансрын гянданд хоригдож энэлэгсэд

Амгалан ажрагсадын хөвгүүн хэмээн өгүүлэгдээд

Аяа, Ертөнцийн тэнгэр хүмүүний мөргөлийн орон болюу”/1.9/

“Өөрийгээ энхрийлэх шуналаа бусдыг энхрийлэх сэтгэлээр арилжих”:

Энэхүү дээд сэтгэлийг төрүүлэх хоёр үндсэн увдис бий. Нэг нь Адиша гэгээнээс дамжсан “Шалтгаан үрээр дамжих долоон увдис” болон нөгөө нь Шантидэва гэгээнээс уламжилсан “Өөрийгээ бусадтай арилжих бодь сэтгэлийн увдис” болой.

Энэ үесийн “арилжих” гэдэг нь чухамдаа тэргүүлшгүй цагаа с эдүгээ хүртэл дадаж сурч ирсэн “өөрийгээ энхрийлэх баригч мунхаг сэтгэлээ”, “бусдыг энхийрлэн үзэх бодь сэтгэл”- ээр арилжин солих буюу өөрийн үндсэнд байгаа буруу муу бодлын “зэвт төмрөө”, өөрөөсөө түрүүнд үргэлж бусдыг харйлах, үлэмжийн чанарт бодь сэтгэл “алт” болгон хувргахад чухам энэ бодь сэтгэл мэргэн болохыг тодложээ. Энэ бол Дээр өгүүлсэн Шанти дэвэ гэгээнээс дамжсан “Өөрийгээ бусадтай ариожих бодьсэтгэлийн увдис бөлгөө. Шантидэвэ гэгээн “Бодисадвын явдалд орохуй”-даа:

“Ертөнцөд амгалан юу буй

Тэр бүхэн бусдыг жаргуулах сэтгэлээс төрөү

Ертөнцөд зовлон юу буй

Тэр бүхэн өөрийгээ жаргаах хүслээс уршигдую/8.130/

хэмээгээд,

“Өөрийн жаргалыг бусдын зовлон лугаа

Үнэхээр эс арилжваас

Бурхан үл бүтэх бөгөөд

Орчлон дор ч жаргал үл гарах /8.131/” хэмээн хоёр сэтгэлийн байрыг сольж арилжин өөрийн үндсэнд бу аминч буруу, мунхаг бодлоос ангижирч хүнлэг гэгээн сэтгэлийн мөн чанарт бусдын тусад гэгээрлийн хутагийг чухалчлах хүний сэтгэлийн дээд болсон бодь сэтгэлийг төрүүлэх, улмаар түүний хүчийг олж сэтгэл оюунаа хөгжүүлэх нь их хөлгөний эрхэм гол мөн болохыг үзүүлжээ. Эл утгыг тодотгон Монголын гүн ухаантан Агваанбалдан бээр:

“Өөрөө л жаргаваас сэтгэл баясах нь

Өтөл миний адилын амьтны нийтийн /эгэл/ ёсон

Өөрөөс бусад нь жаргаваас сэтгэл баясах

Өмнө гараагүй ёс нь бодь сэтгэл Танаас мэндэлжээ.”

“Өөрт зовлон гарах вий хэмээн

Үхтэлээ айдаг нь нийтийн ёсон

Өөрөөс бусад л зовчих вий хэмээн

Үлэмж айх эрдмээр Таны сэтгэл ялгарна.” хэмээн бодь сэтгэлийн эрдэм чадал нь эгэл биднийхээс хэрхэн ялгарах болохыг ийн тодолжээ.

3. Хоосон чанар ба түүнийг онох ухаан

Буддха багш бээр зовлонгийн үндэс алив юмс үзэгдлийн мөн чанарыг зөв ойлгож ухаараагүй мунхаг сэтгэлээс үүдэлтэй гэж үзээд, харин жаргалд хүрэх зөв зам бол юмс үзэгдлийн ахуй ёсыг зөв ухаарсан гүехэн бус гүн ухаарал, дотоод гадаад ертөнцийн харилцан шүтэлцээ, матиараллаг болон оюунлаг оршихуйн зөв зохицол, хүн байгаль хоёрын хурах эс хурахын нарийн холбоо, төрөх түрдэхүй, ирэх одохуй, нэг ба олон, тасархай ба мөнхдөхүйн зэрэг элдэв юмс үзэгдлийн эсрэг тэсрэг мэт боловч басхүү эвлэн нийлсэн тэр олон харилцааны хөгжил хөдөлгөөн дунд, алив туйлшрал хязгаарт баригдахгүй, дээд үнэнийг олсон оносон билиг ухаанаас жаргалын зам мөр эхлэнэ. гэж хөгжлийн үндсийг зөв сэтгэл, зөв ухааны үзүүр үндэстэй холбож, ер жаргалтай сайн сайхан амьдрах гэдэг хүний өөрийн оюун ухаан, сэтгэл санааны ухааны хүчин зүйл, түүний хөгжил, боловсролтой хамааралтай хэмээн үздэг билээ.

Хоосон чанар нь ердийн нэг ухааны орон биш бөгөөд хутагтын буюу дээд ухамсрын түвшинд ойлгогдох гүн утгат мэдэгдэүүн учраас түүнийг энгийн ухааны түвшин ойлгох ухаарах олон арга ухааныг хожмын мэргэд **улам тодруулан тайбларлаж хоосон чанарыг онох зөв мөрийг уламжилжээ. Энд товчлон хоосон чанарыг онох зарим арга ухаанаас дурдсу.**

“Хаагдахуун утга буюу мунхаг бодол, буруу үзлээ мэдэх арга”:

Хоосон чанарыг зөв онохын тулд юун түрүүнд түүний буруу тал болох алив юмс “үнэхэээр бүтсэн”, “би-гээс бүтсэн”, “өөрийн мөн чанараар бүтсэн” гэх зэрэг буруу баримтлалууд, эндүү ташаа бодлууд, мөнхөд барих, тасархайд барих зэрэг туйшралууд, чанх буруугаар гүтгэгч буруу үзлүүд ба тэдгээр буруу үзлийг баригч мунхаг ухаан зэргийг танин барьж хаах хорих хэрэгтэй гэж үзнэ. Дээрх буруу үзлүүдийг нийтэд нь “хаагдахуун”, “хоригдохуун” гэсэн хүрээнд авч үздэг. Хаагдахуун бол мунхаг ухаан, хаагдахуун бол буруу үзлүүд гэж үзнэ. Эдгээр хаагдахуун утгуудыг зөв танин барьж тэдгээрийн ерөндөг зөв ухааныг хөгжүүлснээр мунхагийн үндсийг хааж, зовлонг хорьж, амгалан нирваанд хүрнэ гэж үзнэ.

Ер нь хаагдахуун буюу мунхаг буруу үзэлд хязгаар байхгүй боловч энэ үед хураангуйлан дараах

А. “Бодгалийн (цогцосоо) би-д баригч” болон

Б. “Ном юмсыг би-д баригч” хэмээх гэж хоёр их буруу үзлийн хүрээнд багтааж авч үздэг.

Үүнээс “бодгалийн би-д барих үзэл”-ийг “эвдэрэхүй үзэл” хэмээн нэрлэж энэ хүрээнд авч үздэг буй. Энэ бодгалийг бүрдүүлэгч таван цогц буюу дүрс,

хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, амсуурга, тийн мэдэхүй гэсэн таван нэрийдэх суурийг буруугаар ухаж тэдгээрийг би хэмээн баримлах" зэрэг буруу үзлүүд байдаг аж.

1. Дүрс нь би бус атал би хэмээн үзэх,
2. Би нь дүрстэйгээ өөрийн чанараар төгөлдөр бус атал би хэмээн үзэх,
3. Дүрсэнд би нь өөрийн чанараар чинагш шүтдэггүй адал би хэмээн үзэх,

4. Би-д ч дүрс өөрийн чанараар инагш шүтдэггүй атал би хэмээн үзэх зэрэг буруу дөрөв ба. дээр өгүүлсэн эл дөрвийг үлдсэн дөрвөн цогцос буюу хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэл,дээр буулгаад нийт хорин буруу үзэл болно.

"Мадхьямакаавтара" гаас:

"Дүрс би бус, би дүрс лүгээ төгөлдөр бус

Дүрсэд би үгүй, би-д дүрс үгүй

Тэр мэт хамаг цогцосыг мэдэгдэхүй

Тэдгээрийг хорьсон нь би үгүй хэмээх үзэл хэмээн таалмуй"6.144 хэмээх зэргээр айлдсан байна.

"Судар"-аас: "Эвдрэх үзлийн өндөр уулын хорин оргилыг бэлгэ билгийн очироор дарж үргэлжид орохын үрийг үргэлжид илт үйлдэнэ." хэмээсэн утгыг Богд лам бээр: "Эхлээд сансрын гэм эргүүг сайтар мэдэж, түүний үндэс юу болохыг танин барих, улмаар түүнийг тэвчихийн арга ухааныг олж, хаагдахуун-шунах орныг хорих ба улмаар би үгүй үзлийг магадтай олоод тэр утгыг ижилсүүлэн үйлдэх нь их бага аль ч хөлгөнд хэрэгтэй г мэдээрэй" хэмээн тодлон авч үзсэн буй. Мөн "Мадхьямакаавтара" гаас: "Би үгүйг оносон бэлгэ билгийн очироор

Би-гийн уулыг дарахад түүнтэй хамт төрсөн алив ч эвдрэх

Эвдрэх чуулганд би хэмээн үзэхийн бат уулсыг эвдсэн лүгээ хамт нэгнээ

Түүнд орших эдгээр өндөр үзүүр эвдэрмой" 6.145.

Мөн хаагдахуун "Номын би"-д: Хаагдахуун-номын би-д барих үзэл болон мунхаг нь зөвхөн бодгаль төдийгүй хамаг юмс үзэгдэлд хандах, барих, тэдгээрийг онож мэдэхдээ - ор ь ганцаар, ямар шалтгаан нөхцөлаас хамаарахгүй, "үнэхээр бүтсэн" мэтээр буруу гүтгэж үзэх зэрэг үзлүүд багтдаг байна. Үүнээс заримыг дурдахул:

- "Үнэмлэхүй бээр бүтсэн" (dondambar drub pa, ultimate existance)
- "Үнэхээр бүтсэн"(bdenbar grub pa, true existence)
- "Үнэнээр бүтсэн"(yangdag bar drub pa, true establishment)
- "Өөрийн бэлгэ чанараар бүтсэн"(rangi mtsanyid kyis drub pa, natyral existence or existence by way of its own charectery)
- "Өвөрчлөнгөөр бүтсэн"(rang bzhing gyis drub pa, inherent existance)

- “Өөрийн чанараар бүтсэн” (rang gi oро nyad kyis drub pa, existence, through own entitiness)
- “Өөрийн зүгээс бүтсэн”(rang dgos nai drub pa, existence from the objects side)
- “Байж чадахаар бүтсэн”(tsig tuv du drub pa,)
- “Эдтэй еэ бүтсэн”(rdzad yod, substancial existance)
- “Ахуй ёсоор бүтсэн”(gnas lugs kyis drub pa,) зэрэг буй.

Чингээд их хөлгөнд суралцагч нирвааныг хүсэгч егүзэр тэрээр, хоёр би үгүй -н дотроос эхлээд “бодгалийн би түүнийг өөрийн чанараар бүтсэн”-ийг хорих учиртай.Шунал тачаал зэрэг элдэв муу сэтгэл/нисваанис/ болон төрөх, өтлөх, үхэх, өвдөх зэрэг зовлон бүхэн “эвдрэх үзлийн чуулган”-аас уршигдах жамтайг ухаарах буюу “би” гэдэг тэрхүү эвдрэх үзлийн “ шунах орон” мөнийг мэдсэнээр уг эвдрэх үзлийг арилгах хүсэл төрнө. Чингэх албатай. Тэрхүү шуналын орныг сөхөөж гаргахгүй бол тэр бүхнийг (эвдрэх үзлийн чуулганыг)* хөөж гаргаж чадахгүйд хүрдэг байна.

Богд Зонхава бээр: “Эхлээд сансрын гэм эргүүг сайтар мэдэж, түүний үндэс юу болохыг танин барих, улмаар түүнийг тэвчихийн арга ухааныг олж, хэтрүүлэлгүй шунахын орныг хорих ба би үгүй үзлийг магадтай олоод тэр утгыг ижилсүүлэн үйлдэх нь их бага аль ч хөлгөнд хэрэгтэй г мэдээрэй” хэмээжээ. Мөн “Мадхьямакаавтара” гаас: “Эвдрэх чуулганд үзэхүйгээс нисванис гэмүүд

Хоцрол үгүй гарах хэмээн оюунаар үзээд

Би-г үүний орон болгож онож бүрүүн

Егүүзэр бээр би-г түрдгэгтүн” **6.120.** хэмээн эдгээр хаагдахуун буюу мунхаг ухаан, буруу үзлийг хорих эхлээд хорих хэрэгтэй нь:

Хаагдахуун буруу үзлийг няцаах ухаан буюу хоосон чанарыг онохуй:

Хоосон чанар нь зовлонболон түүний шалтгааныг дарах ерөндөг болох нь:

Хоосон чанар болон түүнийг онох ухааныг олохын гол хэрэг тус нь хамаг амьтныг зовлонгоос ангижруулж, түйтгэрээс гэтэлгэж, нирвааны амгаланд хүргэх буюу гэгээрэхүйн дээд хутагт хүргэхэд оршдог. Энэ нь их хөлгөний мөрд сурч судлах үйлийн эрхэм зорилго мөнийг “хэдий их хөлгөнөөр замнаж магад гарах санаа, бодь сэтгэл зэрэгт суралцах нь зүй бөгөөд түүний хамт хоосон чанарыг онох ухаан буюу шүтэн барилдахуйг онох ухаанд эс суралцваас сансрын зовлонгийн үндсийг ёзоороос нь хааж, хорихуй үнэнийг онож, нирвааны амгаланд хүрч чадахгүй тул энэхүү хоосон чанар буюу би-үгүй үзэл зөв үзлийг онохоор шамдах чухал хэрэгтэй гэж үзнэ. Эл учрыг Монголын гүн ухаантан Бари лам Дамцэгдорж бээр: “Ном юмсын өөрийн чанараар бүтээгүй хоосон буюу би үгүйн хоосон чанар байна. Ялж төгөлдөр нөгчигсэн бурхан бээр хоосон чанарын суурийг номын болон бодгалийн хоосон чанар хэмээх хоёр зүйлээр айлдсан ажгуу. Ийн айлдахын хэрэг тус буй. Их бага хөлгөний амьтан бүгдээр хоёр түйтгэрээс лавтай яа гэтлэхийн тухайд болой.” хэмээн нотлохуйн ухааны үүднээс тайлбарласнаас үзэхүл тод буй.

Хоосон чанар болон шүтэн барилдахуй хоёрыг нэгэн утганаа авч үзэх:

Ер хоосон чанарын ухханы үндэс нь Бурхан багшийн хоёрдугаар номын хүрд буюу бэлгэ чанар үгүй болохыг үзүүлсэн номоос уламжилсан гэж үздэг. Тиймээс “Билгийн чинад хүрэхүй” буюу судрын аймгийн ном сургаалд суурилсан байна. Мөн энэ номын хүрдэнд их хөлгөний ёсны дээд мөр болсон нууц тарнийн сургаал багтдаг. Иймээс их хөлгөнийг түүний үндэс болох билгийн чинад хүрэхүйн ёс хийгээд үр болох тантрын ёс гэсэн хоёр их утганаа багтааж учир шалтгааны үүднээс барилдуулан нэгтгэж үздэг байна. Хоосон чанарын гүн утгыг сударт үзүүлснээс эшлэвэл ийн буюу.

“Билгийн зүрхэн судар” аас: “Дүрс хоосон болой. Хоосон дүрс болой. Дүрсээс бээр хоосон өөр бус, Хоосноос бээр дүрс өөр бус болой” хэмээх зэргээр олон буй.

Энэ үзэл нь их хөлгөний үзэл онол, тошгсон таалын ёсны эрхэм гол бөгөөд Их хөлгөний тогтсон таалын аймаг болох “Сэтгэлийн төдийтэн” , “Төв үзэлтэн” нарын үзэд онол болон хөгжиж иржээ. Энэтхэгийн их эрдэмтэн бандида, их хөлгөний төв үзлийн журмыг нээгч Нагаржуна гэгээн бээр “Үндсэн билиг” шастараа:

“Алин бээр шүтэн барилдаж гарсан

Хаагдах үгүй, төрөх үгүй

Тасархайтах үгүй, мөнхдөх үгүй

Ирэх үгүй, одох үгүй

Тусгаар утгат бус, нэгэн утгат бус” хэмээн “бурхан багшийн ном сургаал, үзэл онолын зүрхэн - хоосон чанарын гүн утгыг **“найман үгүйсгэл”** хэмээх энэ цөөхөн үгэнд багтаан тайлахдаа, **“хамаг юмс үзэгдэл хэдий хоосон чанартай ч басхүү шүтэн барилдахуйн мөн чанарт нэгдэн орших”** бөгөөд тэр нь утгыг онож чадваас хамаг зовлон амирлах нирваан хутаг буюу бурханы эрдэм ухаанд төгс болно” гэсэн нарийн ухааныг хамтатган илэрхийлжээ.

Чингэхдээ найман үгүйсгэлийн суурь болгож:

- “Мөн чанартай” харьцуулж арвидах хомсдохын үүднээс “төрөх ба түрдэх” хоёрыг,
- “Цаг хугацаанд” харгалзуулж “Мөнхдөх, тасархайтах” хоёр”-ыг,
- “Орон вишайд” харгалзуулж “ирэх одох хоёр”-ыг,
- “Хань нөхөр”-т харгалзуулж “нэг болон тусгаар утга” хэмээх ертөнцийн ердийн нэр томьёог хослуулан аваад
- “Ахуй ёс”,
- “Орон зай”,
- “Цаг хугацаа”,
- “Бодит ба хийсвэр” гэсэн агуулгуудын жинхэнэ мөн чанар чухам юу болохыг шинжиж үзүүлжээ.

Улмаар агшинаа эвдэрэх **“Хаагдах” (түрдэх) утга** ба, өөрөө бодитойгоор орших **“Төрөх”** ба, урьдын үргэлжлэл **“Тасрах”** ба, цаг үргэлжид орших **“Мөнхрөх”** ба, холын орноос ойртож **“Ирэх”** ба, холын оронд явж **“Одох”** ба, **“Тус тусдаа байх”** ба, утга нь тус тусдаа бус **“Нэг байх”** зэрэг

эдгээр найман утгуудад “өөрийн мөн чанараар бүтэх” (өвсбээн бүтэх) хэмээх нь огт олдохгүй болж гагцхүү харилцан бие биедээ харилцан хамаарах, харилцан бие биенд шүтэлцэж агуулагдахаас бус өөрөөр орших аргагүй учраас “үнэхээр **“Үгүй” буюу** хоосон чанарт болно гэсэн дүгнэлтэд хүргэнэ.

Шүтэн барилдахуйн нэгэн гол утга бол шалтгаан нөхцөлөөс үүдэх, тэдгээрт дулдуйдан бүтэх бөгөөд тийм чанартай учир юмс хоосон чанартай мөний нэг нотолгоо болно гэж үзнэ. Монголын Дандар аграмба бээр “Шүтэн магтаалын тайлбар”-таа:

“Алин шалтгаанд харгалзах тэр мөн бөгөөс

Тэр тэр ямагт өвөрчлөн чанараар хоосон мөн”

хэмээсэн нь өөрийн мөн чанар байхгүй хоосон хэмээхийн нэг чухал учир нь алив ном юмс өөрийн учир шалтгаан нөхцөлд дулдуйдаж буюу шүтэж бий болдогт оршихын энд онцгойлон үзүүлжээ.

Эл гүн утгын талаар монголын эрдэмтэн судлаачид анхааралаа хандуулж цөөнгүй бүтээл туурвил туурвисаны дотор академич Ш. Лувсанвандан, академич Г.Лувсанцэрэн, доктор Г. Лодой, доктор М. Гантуяа нар өөрсдийн бүтээлүүдээ тусгайлан авч үзсэнийг эл дашрамд дурдаж байна.

Хоосон чанарыг онох нотлол ухаан:

1. “Үндсийг шинжих - Очирт цацлын нотлох ухаан”: “Бодас (бодит юмс) байна. Үнэхээр төрөхгүй буюу. Өөрөөс, бусдаас, хоёулангаас болон, шалтгаан байхгүйгээс үл төрөх учраас”

2. “Үрийг шинжих - Буй, буй бус, төрөх, түрдэхийг няцаах нотлох ухаан “Ногоо байна. Үнэхээр /өвөрчлөнгөөр/ төрөх үгүй л дээ. Буй нь үнэхээр бүтэж төрөх үгүй буюу. Буй бус нь ч үнэхээр бүтэж төрөх нь ч үгүй учраас. Үлгэрлэвээс, Хүүсэр эмийн хөвгүүн адил болой.”

3. “Мөн чанарыг шинжих - Шүтэн барилдахуйн нотлох ухаан”: “Бодит үзэгдлүүд байна. Үнэхээр өвөрчлөнгөөр байхгүй л дээ. Аливаа үр нь шалтгаан нөхцөл дөхөхөөр (бүрдэх) үзэгдэх бөгөөд шалтгаан нөхцөл байхгүй бол үл үзэгдэх засварт буюу шүтэн барилахуйн мөн чанарт болж үндэс үр дагаврыг дагалдан орж буцах болой. Үлгэрлэвээс, Толинд буусанд хөрөг дүрс чинь толь болоод нүүр хоёр дөхөж ойртсоноор үзэгдэх буюу.

Шүтэн барилдахуйг онох ухаанаар туйлшрах буруу үзлийг хорих:

Мэдэгдэхүүн байна. Шүтэн барилдахуйг мэдсэн тэр ухаанаар өөрийн чанараар баригч мөнхийн үзэл болоод хойшдоо үр гарахгүй гэж үзэгч тасархай үзэл тэргүүтэн муу үзлийн тор бүхнийг таслах мөн. Учир нь бодас юмс нөхцөл шалтгаанд шүтэн буй болдог мөнийг оносноор өвөр бусдаас төрнө гэх зэргээр туйлшран барих буруу үзлүүд гарахгүй болно. “Мадхьямакаавтара” гаас:

“Алины тул бодас маш шүтэж болсноор

Эдгээр атхагийг шинжлэн үл чадах

Тиймийн тул эдгээр шүтэж болсон ухаанаар

Муу үзлийн тор бүхнийг тасалмуй” 6.115

“Модон тэрэг”-ний шинжлэл: “Би”-нь модон тэрэг адил долоон хязгаарт буй бус ч, шүтэн нэрийдсэн төдий болох нь:

“Мэдэгдэхүүн байна. Модон тэрэгээр үлгэрлэн “Би”-г шинжвээс үл олдох мөн. Модон тэрэг нь, Өөрийн бүрдүүлэгч гишүүдээс /хэсгүүд/ ангид “эдэт” гэж үзэгдэх бус /1/, Тэдэнтэй нэг болж бүтсэн бус /2/, Өөрийн гишүүдтэй өөрийн чанараар төгөлдөр бус /3/, Өөрийн гишүүдийн дээр гадна талаас өөрийн чанараар шүтсэн бус /4/, Гишүүд тэдгээр нь өөрийн чанараар дотроос модон тэрэг түүнд шүтсэн ч бус /5/, Гишүүд хуран чуулсан төдий нь модон тэрэг бус /6/, Гишүүдийн хэлбэр төдий нь модон тэрэг бус /7/ мөн тул.”

Ийнхүү модон тэргийг хайж шинжтэл эс олдохын адилаар “би хийгээд цогцос” хоёрыг тийн мөнийг мэдэхтүн. *“Мадхьямакаавтара”* гаас:

*“Тэрэг нь өөрийн гишүүдээс ангид бус,
Ангид бус бээр бус, түүн лүгээ төгөлдөр бээр бус,
Гишүүнд бус, гишүүнүүд түүнд бус,
Хурсан төдий бус, хэлбэр бус урьдчилан болой.” 6:151*

“Мэдэгдэхүүн байна. Төв үзэлтний ёсноо, нэрийдлийн суурь модон тэрэг нь шүтэн нэрийдэх төдийд бүтсэн төдийгүй. Модон тэрэг, түүний үе хэсгүүд зэрэг нэрийн ялгамжаа зэрэг бусдыг ч ухаанаар шинжиж эрэвч олдохгүй. Гэсэн ч ертөнцөд алдаршсан нэрийн үүднээс бол үгүйсгэхгүй үзнэ. Модон тэрэг нь хүрд дугуй өөрийн хэсгүүдэд харгалзан гишүүнт болох, Өөрийн хувь хэсэгт харгалзан хувьт болох, модон тэрэг өөрийн нь чухалд авах, авах үйл зэрэгт харгалзан үйлдэгч гэх, явагч одогч гэж хэлэгдэх, тэрэгний гол зэрэгт харгалзан чухал авагч, эсвээс хүмүүст харгалзан чухал хэрэглэгдэгч /хэрэглээ/ болох зэргээр бүтсэн мөн тул” хэмээх зэргээр нотлол, хэтрүүлэлийн үүднээс их хөлгөний төв үзлийн ёсноо хоосон чанарын гүн утгуудыг нээн үзүүлсэн буй.

Их хөлгөний үзэл буюу төв үзлийн тус эрдэм мөн чанар:

Агваанбалдан цорж бээр: “Бултыг мөнхөд баримтлахуйн газар шороонд үл унагч, Буйд тасархайд үзэхүйн огторгуйд үл хөөрөгч, Бусчир туйлшрах үзлийн хамаг харанхуйг арилгагч Боловсрон гэгээрэх мөрийн **Наран** танаа мөргөмү”, “Үйл нисваанисын хороор үл дийлдэн Үнэнд үзэгч могойн амийг эрхшээн Үлшгүй хоосон чанарын агаарт үргэлж цэнгэх Үлэмж гүн мөрийн **Хангарьд** танаа мөргөмү”, “Эвт шүтэн барилдахуйн зааны /нуруун/ дээр залран Эндүү ташаагүй ухааны очир юуг тэврэн, Энхрийлэн би-д баригч уулыг сөгдүүлэгч, Энх амгалангийн мөрийн **Хан хурмаст** танаа мөргөмү” хэмээх зэргээр төв үзлийн мөн чанарыг “Наран”, “Хангарьд”, “Хан хурмаст” ертөнцөд буянтай, олон хамаг амьтанд тус болдог Тэнгэр, Лус, Наран саран зэргээр үлгэрлэн хоосон чанарыг онох ухаан, төв үзлийн тус эрдмийг үзүүлсэн зэрэг нь дээрх мэт олон бөлгөө.

Их хөлгөний арга билиг: *“Гаяагори”*-д: “Бодьсадва нарын мөрийг товчлон хурааваас хоёр буюу. Хоёр алин хэмээвээс, энэ мэт буюу. Арга болоод билиг болой” хэмээсэн буй

“Димэддагвын үзүүлсэн судар”-т: Аргаар эзлэгдсэн билиг нь нирваан болой. Билгээр үл эзлэгдсэн арга нь хүлээс болой. Билгээр эзлэгдсэн арга нь нирваан болой” хэмээн ихэд тодорхой айлдсан буй. Их хөлгөний арга бол их нүүлсэхүйсэтгэл, бодь сэтгэл, өглөг, шагшабад, тэсвэр, хичээнгүй, самади барамид зэрэг таван барамид, мөн янагуух буяны чуулган зэргүүд багтах бо аргын талд хоёр би үгүйг онох ухаан, хоосон чнарыг онох ухаан, билиг барамид тэргүүтэн, бэлгэ билгийн буяны чуулган зэргүүд буюу үндсэндээ арга болох сэтгэлийн тал, билиг болох ухааны тал хоёрыг энд арга билиг хэмээн үздэг. Чингэхдээ арга билиг хоёр нь амгалан нирваан хутагийг бүтээхдээ өрөөсгөл хос бусаар бус нэгдэж нийлж хослож бүтээх учиртай аж. “Димэддагвын үзүүлсэн судар”-т:

Аргаар үл эзлэгдсэн билиг нь, хүлээс болой.

Аргаар эзлэгдсэн билиг нь нирваан болой.

Билгээр үл эзлэгдсэн арга нь хүлээс болой.

Билгээр эзлэгдсэн арга нь нирваан болой” хэмээн ихэд тодорхой айлдсан буй.

Дүгнэхүй:

“Их хөлгөн” хэмээх энэ их эрдмийн далай ухаанаас дуслын төдийг эдүгээ сурах судлахыг эрхэмлэгч хэн бүхнээ өчүүхэн ч атугаа тус нэмэр боолоосой гэхий үүднээс онол, арга зүйн гол зарчмуудаас тоймлон буулгахаар оролдсон нь энэ бөлгөө.

“Их хөлгөн бол буддын гүн ухааны ертөнцийг үзэх үзэл онол, хүнийг хөгжүүлэх дотоод ертөнцийн их мөр, оюун ухааны их гэгээрэлд хүрэх удвис бүтээлийг нэгтгэсэн, тэдгээрийг сэтгэл ухааны буюу арга билгийн товчоонд нийтгэсэн билгийн чинад хүрсэн- хүн төрөлхтний эрдэм ухааны их сан хөмрөг, оюуны их бүтээлийн уурхай хэмээн үзэж байна. (Т.Булган Ph.D, MUIS 2011.05.15)

SUMMARY

This small article covers some essiantis of Mahayana Vehicle of Buddhism. “Everybody want to have happiness, nobody want to experience of suffering. That is the common wish and dream of all sentient beings all over the universe.” How can we, human, fullfil our eternal dream into real life. There are mainly the aspects concerning the great compassion, awakening mind, middle view as basic principle of Mahayana philosophy or tenets. Touching with main principles of Mahayana, some difinations, notes, comments based on works of from India, Mongolia and others are coupled within this presentation.

Main goal of Mahayana is to achieve Enlightenment One or Maha Nirvana which shuold be accomplished by the means and wisdom of Mahayana for the benefit of all sentient beings. Hence to remove all obscuration of his appliction and his knowledge, the yogins must continually cultiwate the perfection of wisdom together with means. In this context, the means of mahayana take place the engaging in Bodhichitta mind rooted at Great Compassion etc. Then it developed by practices of mind such as paramittas as giving, allertness, patience,entusiasmm,meditation etc.

In order to freed from all sufferings in cyclic existence, all these practises were taught by the mighty one for the sake of wisdom. Therefore those who wish to pacify suffering should generate this wisdom or Prajna paramitta. On contemplating proof of emptiness or non existence, Such proofs as “there are never any entities in which arising exists, from themselves, from another, from both, nor

without cause." And entities are empty of intrinsic nature" on dependent origination, are explained here by great thinkers and scholars of Mahayana from India, Mongolia, Tibet and others.

Conclusion: "May old mother like sentient beings, Be attained the Holder of Omniscience, And be traveled through the way of Enlightenment with miracles, By the virtue of spring of the Awakening Mind.

НОМ ЗҮЙ

1. "Билгийн зүрхэн"
2. "Алтангэрэл"
3. "Очироор огтлогч"
4. "Үндсэн билиг"
5. "Дөрвөн зуут"
6. "Мадхьямакааватара"
7. "Бодьчарияаватара"
8. "Тогтсон тааллын агуулга Эрдэнийн эрхи"
9. "Болорын толь"
10. "Дунта зава"
11. "Арга билиг хосолхуй"
12. "Маанийн гүн бүтээл"
13. "Ээжийгээ танихуй", "Бодь мөрийн гурван эрхэм"
14. "Бодь мөрийн зэрэг"
15. "Сайн хувьтны орох олом",
16. "Бодьсавын далайд орох олом"
17. "Шүтэн барилдахуй магтаалын тайлбар цөөн үгт тодорхой утгат"
18. "Билгийн зүрхэн судрын тайлбар"
19. "Магад ба удирдахуй утгын сайн номлолын зүрхэн" зэрэг судрууд.